



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Налайхын Дулааны станц ТӨХК-ийн 2024 оны санхүүгийн тайланд  
хийсэн аудитын тайлан

**Аудитын код: НТАГ-2025/001/НА-СТА-ТӨҮГ**

Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Улаанбаатар хот 2025 он	Нийслэл дэх Төрийн аудитын газрын дэд дарга	Ч.Болд
	Утас: 7000-7734	Цахим хаяг: <a href="mailto:boldch@audit.gov.mn">boldch@audit.gov.mn</a>
	Санхүү-нийцлийн аудитын хэлтсийн дарга	Х.Түвшинбаяр
	Утас: 315558	Цахим хаяг: <a href="mailto:tuvshinbayarkh@audit.gov.mn">tuvshinbayarkh@audit.gov.mn</a>
	Аудитын менежер	Я.Алтанцэцэг
	Утас: 325093	Цахим хаяг: <a href="mailto:altantsetsegya@audit.gov.mn">altantsetsegya@audit.gov.mn</a>
	Ахлах аудитор:	Ё.Лхагвадулам
	Утас: 325093	Цахим хаяг: <a href="mailto:lkhagvadulamyo@audit.gov.mn">lkhagvadulamyo@audit.gov.mn</a>

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу

## Нэг.Хараат бус аудиторын дүгнэлт



### ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,  
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,  
Утас:7000 7734, Факс: (976-11) 32 01 54

И-мэйл: [ub@audit.gov.mn](mailto:ub@audit.gov.mn), Вэбсайт: [www.audit.mn](http://www.audit.mn)

᠑᠔᠒᠑.03.14 № 01/᠒54  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-Т

НАЛАЙХЫН ДУЛААНЫ СТАНЦ  
ТӨХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ  
ЗАХИРАЛ Ц.ЭНХТҮВШИН  
ТАНАА

### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Налайхын Дулааны станц ТӨХК-ийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, орлогын дэлгэрэнгүй, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх орлогын дэлгэрэнгүй, мөнгөн гүйлгээг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Тайлант онд компанийн нийт ажилчдын цалинг 45 хувиар нэмэгдүүлсэн нь ажилтнуудыг тогтвор, суурьшилтай ажиллуулах үр дүнтэй ажил болсон байна.

### Аудитын гол асуудал

Тус байгууллагын тайлант оны зорилтот түвшний орлогын төлөвлөгөө 163.9 сая төгрөгөөр буюу 2.8 хувиар тасарсан, 25.4 сая төгрөгийн ашигтай ажилласан байна.

### Бусад асуудлын хэсэг

Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 8 зорилтын хүрээнд 40 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснийг гүйцэтгэлээр бүрэн хэрэгжүүлсэн гэж тайлагнасан байна.

### Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

#### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ  
АУДИТОР



М.ЭРДЭНЭЖАРГАЛ

## Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Балансын зүйл	Үлдэгдэл	
		1 сарын 1	12 сарын 31
1	ХӨРӨНГӨ	0.00	0.00
1.1.01	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	19,197,864.22	31,643,095.03
1.1.02	Дансны авлага	493,309,414.68	206,121,359.80
1.1.03	Татвар, НДШ-ийн авлага	34,039,090.53	23,521,176.40
1.1.06	Бараа материал	386,088,374.06	399,514,392.93
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	932,634,743.49	660,800,024.16
1.2.01	Үндсэн хөрөнгө	8,027,044,163.78	8,939,792,180.74
1.2.02	Биет бус хөрөнгө	2,008,833,416.94	2,456,315,333.41
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	10,035,877,580.72	11,396,107,514.15
<b>1.3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>10,968,512,324.21</b>	<b>12,056,907,538.31</b>
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ	0.00	0.00
2.1.1.01	Дансны өглөг	1,468,817,075.83	660,736,207.82
2.1.1.03	Татварын өр	328,047,914.21	250,391,791.47
2.1.1.08	Урьдчилж орсон орлого	50,099,521.48	48,038,417.75
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	0.00	31,204.00
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	1,846,964,511.52	959,197,621.04
<b>2.2</b>	<b>Өр төлбөрийн нийт дүн</b>	<b>1,846,964,511.52</b>	<b>959,197,621.04</b>
2.3.01	Өмч: - төрийн	8,703,255,561.66	8,703,255,561.66
2.3.06	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	2,727,654,260.64	2,727,654,260.64
2.3.08	Эздийн өмчийн бусад хэсэг	1,952,180,999.37	3,835,859,163.36
2.3.09	Хуримтлагдсан ашиг	-4,261,543,008.98	-4,169,059,068.39
2.3.09.1	Тайлангийн үеийн ашиг	0.00	25,403,667.86
2.3.09.2	Өмнөх үеийн ашиг	-4,261,543,008.98	-4,194,462,736.25
<b>2.3.11</b>	<b>Эздийн өмчийн дүн</b>	<b>9,121,547,812.69</b>	<b>11,097,709,917.27</b>
<b>2.4</b>	<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН</b>	<b>10,968,512,324.21</b>	<b>12,056,907,538.31</b>

### 2.2 Орлогын дэлгэрэнгүй тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Балансын зүйл	Өмнөх он	Тайлант он
<b>01</b>	<b>Борлуулалтын орлого (цэвэр)</b>	<b>5,075,949,879.45</b>	<b>5,344,286,378.77</b>
<b>02</b>	<b>Борлуулалтын өртөг</b>	<b>7,776,611,757.87</b>	<b>8,911,465,743.24</b>
<b>03</b>	<b>Нийт ашиг( алдагдал)</b>	<b>-2,700,661,878.42</b>	<b>-3,567,179,364.47</b>
04	Түрээсийн орлого	1,963,636.40	2,945,454.60
05	Хүүгийн орлого	445,530.16	1,653,043.53
08	Бусад орлого	217,044,918.19	234,766,328.69
<b>08.1</b>	<b>Орлогын дүн</b>	<b>219,454,084.75</b>	<b>239,364,826.82</b>
10	Ерөнхий ба удирдлагын зардал	256,272,923.62	351,534,357.26
<b>12.1</b>	<b>Зардлын дүн</b>	<b>256,272,923.62</b>	<b>351,534,357.26</b>
17	Бусад ашиг ( алдагдал)	1,972,797,500.70	3,711,586,313.74

17.1	Олз, гарзын дүн	1,972,797,500.70	3,711,586,313.74
18	Татвар төлөхийн өмнөх ашиг( алдагдал)	-764,683,216.59	32,237,418.83
19	Орлогын татварын зардал	0.00	6,833,750.97
20	Татварын дараах ашиг (алдагдал)	-764,683,216.59	25,403,667.86
21	Зогсоосон үйл аж-ны татварын дараах ашиг(алдагдал)	0.00	0.00
22	Тайлант үеийн цэвэр ашиг ( алдагдал)	-764,683,216.59	25,403,667.86

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	0.00	0.00
<b>1.1</b>	<b>Мөнгөн орлогын дүн (+)</b>	<b>8,011,248,267.76</b>	<b>10,871,967,545.41</b>
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	5,592,464,182.77	6,392,743,515.87
1.1.2	Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого	223,047.00	0.00
1.1.3	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	8,936,081.00	4,958,806.00
1.1.5	Татаас, санхүүжилтийн орлого	2,355,000,000.00	4,425,505,000.00
1.1.6	Бусад мөнгөн орлого	54,624,956.99	48,760,223.54
<b>1.2</b>	<b>Мөнгөн зарлагын дүн (-)</b>	<b>8,005,313,291.38</b>	<b>10,786,569,853.67</b>
1.2.1	Ажиллагчдад төлсөн	2,471,306,342.23	3,351,607,208.51
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	926,147,790.05	947,363,929.56
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	316,049,865.00	360,528,834.31
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	1,926,433,706.04	3,013,402,242.55
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс,сэлбэг хэрэгсэлд төлсөн	1,585,575,769.25	1,506,692,425.11
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	279,703,926.43	971,100,718.35
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн	2,132,870.00	2,160,000.00
1.2.9	Бусад мөнгөн зарлага	497,963,022.38	633,714,495.28
<b>1.3</b>	<b>Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>5,934,976.38</b>	<b>85,397,691.74</b>
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	0.00	0.00
<b>2.1</b>	<b>Мөнгөн орлогын дүн (+)</b>	<b>350,294.90</b>	<b>1,609,229.99</b>
2.1.6	Хүлээн авсан хүүний орлого	350,294.90	1,609,229.99
<b>2.2</b>	<b>Мөнгөн зарлагын дүн (-)</b>	<b>56,965,800.00</b>	<b>74,561,690.92</b>
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	56,965,800.00	74,561,690.92
<b>2.3</b>	<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>-56,615,505.10</b>	<b>-72,952,460.93</b>
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	0.00	0.00
<b>4</b>	<b>Бүх цэвэр мөнгөн гүйлгээ</b>	<b>-50,680,528.72</b>	<b>12,445,230.81</b>
<b>5</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>69,878,392.94</b>	<b>19,197,864.22</b>
<b>6</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>19,197,864.22</b>	<b>31,643,095.03</b>

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
01	<b>2022 оны 12 сарын 31-ээр үлдэгдэл</b>	8,703,255,561.66	2,727,654,260.64	1,952,180,999.37	-3,496,859,792.39	9,886,231,029.28
02	НББ-н бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	0.00	0.00	0.00	0.00	0.00
03	Залруулсан үлдэгдэл	0.00	0.00	0.00	0.00	0.00
04	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	0.00	0.00	0.00	-764,683,216.59	-764,683,216.59
09	<b>2023 оны 12 сарын 31-ээр үлдэгдэл</b>	8,703,255,561.66	2,727,654,260.64	1,952,180,999.37	-4,261,543,008.98	9,121,547,812.69
10	НББ-н бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	0.00	0.00	0.00	67,080,272.73	67,080,272.73
11	Залруулсан үлдэгдэл	0.00	0.00	0.00	0.00	0.00
12	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	0.00	0.00	0.00	25,403,667.86	25,403,667.86
13	Бусад дэлгэрэнгүй орлого	0.00	0.00	0.00	0.00	0.00
14	Өмчид гарсан өөрчлөлт	0.00	0.00	1,883,678,163.99	0.00	1,883,678,163.99
15	Зарласан ногдол ашиг	0.00	0.00	0.00	0.00	0.00
17	<b>2024 оны 12 сарын 31-р үлдэгдэл</b>	8,703,255,561.66	2,727,654,260.64	3,835,859,163.36	-4,169,059,068.39	11,097,709,917.27

## 2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

д/д	Үзүүлэлт	Хэмжих нэгж	Өмнөх оны мөн үе	2024 оны		Зөрүү	Гүйцэтгэлийн хувь
				Төлөвлөгөө	Гүйцэтгэл		
1	<u>Бүтээгдэхүүн үйлдвэрлэлт, түгээлт, борлуулалт</u>						
	Дулаан үйлдвэрлэлт	мян.Гкал	97.8	99.1	99.1	0	100.1
2	Нийт орлого	мян.төг	5,295,404.0	5,747,644.4	5,583,651.2	163,993.1	97.1
	Үүнээс: Цэвэр борлуулалт	мян.төг	5,075,949.9	5,589,338.2	5,344,286.4	245,051.8	95.6
	Хүүгийн орлого	мян.төг	445.5	0.0	1,653.0	-1,653.0	
	Бусад орлого /Маягт, тендер техникийн нөхцөл, үнсний, алданги торгуулийн, угаалгын, засвар	мян.төг	219,008.6	158,306.2	237,711.8	-79,405.6	150.2

	үйлчилгээний орлогууд/						
3	Нийт зардал	мян.төг	8,200,996.1	10,422,081.2	9,574,600.2	847,481.0	91.9
	Үүнээс: Удирдлагын зардал	мян.төг	167,843.7	237,999.6	217,763.1	20,236.6	91.5
4	Татварын өмнөх ашиг /алдагдал/	мян.төг	-2,905,592.2	-4,674,436.8	-3,997,782.7	-676,654.1	85.5
	Улсын төсвийн татаас	мян.төг	2,140,909.1	2,181,818.2	4,023,186.4	1,841,368.2	184.4
5	<b>Цэвэр ашиг, алдагдал</b>	<b>мян.төг</b>	<b>-764,683.1</b>	<b>-2,492,618.6</b>	<b>25,403.7</b>	<b>2,518,022.3</b>	<b>-1.0</b>
6	<i>Төсвийн төлбөрт нийт дүн</i>	мян.төг	1,763,802.0	1,618,434.3	1,950,105.3	-331,671.0	120.5
	а/ ААНОАТ	мян.төг	0.0	0.0	0.0	0.0	
	б/ НӨТ	мян.төг	745,761.7	527,914.8	652,331.3	-124,416.5	123.6
	в/ НДШ	мян.төг	767,356.7	636,955.2	947,363.9	-310,408.7	148.7
	г/ ХАОАТ	мян.төг	236,033.7	439,279.4	332,242.6	107,036.8	75.6
	д/ Үл хөдлөх хөрөнгийн татвар	мян.төг	10,345.6	9,870.1	9,870.8	-0.7	100.0
	е/ Тээврийн хэрэгслийн татвар	мян.төг	499.1	529.1	727.5	-198.4	137.5
	ж/ Бусад татвар /Газрын төлбөрт/	мян.төг	1,394.7	1,434.7	700.6	734.1	48.8
	з/ Агаарын бохирдлын татвар	мян.төг	2,410.5	2,451.0	3,472.0	-1,021.0	141.7
	и/ Ус бохирдуулсны татвар	мян.төг			3,396.6	-3,396.6	
7	Төрийн өмчийн ногдол ашигт	мян.төг	0.0	0.0	0.0	0.0	
8	Нийт ажиллагсдын тоо	хүн	113.0	121.0	113.0	8.0	93.4
9	Нийт цалингийн сан	мян.төг	2,896,171.5	4,228,431.1	3,712,099.1	516,332.0	87.8
10	Нэг ажиллагчийн дундаж цалин	мян.төг	2,135.8	2,912.1	2,737.5	174.6	94.0
11	Нэгж бүтээгдэхүүний өртөг ДЭХ	төг	82,410.2	100,906.2	93,444.5	7,461.6	92.6
12	Борлуулалтын 1 төгрөгт ногдох зардал	төгрөг	1.62	1.86	1.79	0.1	96.1
13	Хөрөнгө оруулалт, их засвар, ТЗБАХ	мян.төг	412,237.1	129,461.0	84,233.0	45,228.0	65.1
14	Нийт авлага	мян.төг	527,348.5	420,000.0	229,642.5	190,357.5	54.7
	Үүнээс: Найдваргүй	мян.төг	0.0	0.0	0.0	0.0	
15	Нийт өглөг	мян.төг	1,846,964.5	1,170,000.0	959,197.6	210,802.4	82.0
	Үүнээс: Богино хугацаат	мян.төг	1,846,964.5	1,170,000.0	959,197.6	210,802.4	82.0
	Урт хугацаат өр төлбөр	мян.төг	0.0	0.0	0.0	0.0	0.0

## Гурав. Аудитын илрүүлэлт:

Аудитаар нийт 2,958.8 мянган төгрөгийн 1 алдаа<sup>1</sup> илэрснийг аудитын явцад залруулаагүй тул зөвлөмж өгөв.

Аудитаар нийт 9,568.4 мянган төгрөгийн зөрчил<sup>2</sup> илэрснээс 5,607.6 мянган төгрөгийн зөрчилд 2 төлбөрийн акт тогтоож, 2,143.9 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүлж, 1,816.9 мянган төгрөгийн зөрчилд давтан гаргахгүй байх 1 зөвлөмж өгсөн.

### 3.1 Төлбөрийн акт

3.1.1 Шатахууны зардлыг батлагдсан төлөвлөгөөнөөс илүү зарцуулж, анхан шатын бүрдэл дутуу баримтаар 5,257.6 мянган төгрөгийн гүйлгээ хийсэн нь Эрчим хүчний сайдын "Налайхын Дулааны станц" ТӨХК-ийн 2024 оны техник, эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин батлах тухай" А/01 тушаалын хавсралтаар баталсан зардлыг хэтрүүлсэн, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэж заасантай нийцээгүй, санхүүгийн тайлагналын "нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Батлагдсан төлөвлөгөөнөөс илүү зарцуулж, анхан шатны баримтын бүрдэлгүй гүйлгээ хийсэн 5,257.6 мянган төгрөгийг төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоов.

3.1.2 Харилцагч байгууллагатай худалдан авах гэрээг байгуулахдаа ирүүлсэн үнийн саналаас 350.0 мянган төгрөгөөр илүү байгуулж, шилжүүлсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5.1.4-т "Үнэн зөв байх" гэж заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлагналын "хэмжилт" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Үнийн саналаас илүү тооцож шилжүүлсэн 350.0 мянган төгрөгийг төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоов.

### 3.2 Албан шаардлага

Өмнөх онуудаас шилжин ирсэн 2,143.9 мянган төгрөгийн авлагын үлдэгдлийн тооцоог хийж, баталгаажуулаагүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч,

---

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

<sup>2</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

худалдан авагчтай тооцоо хийж, үлдээдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж заасантай тус тус нийцээгүй, санхүүгийн тайлагналын "эрх ба үүрэг" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

*Шийдвэрлэсэн нь:* Авлагын тооцоог хийж, баталгаажуулаагүй зөрчлийг зогсоож, давтан гаргахгүй ажиллах, өмнөх оноос шилжин ирсэн авлагыг барагдуулах албан шаардлага хүргүүлэв.

### **3.3 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Урьдчилж орсон орлогын данстай холбоотой асуудал

*Илрүүлэлт:* Урьдчилж орсон орлого дансанд Ковид-19 цар тахлын үед төрөөс хэрэглэгчдэд халаалтын үнийн хөнгөлөлт үзүүлэхэд Диспетчерийн үндэсний төв ТӨХК-аас орж ирсэн 1,485.9 мянган төгрөгийн санхүүжилтийн үлдэгдэл, харилцагч тодорхойгүй орлого 331.0 мянган төгрөгийн үлдэгдэл байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдээдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж заасантай тус тус нийцээгүй, санхүүгийн тайлагналын "эрх ба үүрэг" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

*Өгсөн зөвлөмж:* Урьдчилж орсон орлогын дансанд бүртгэлтэй эзэн тодорхойгүй үлдэгдлийг орлогоор бүртгэх зөвлөмж өгөв.

2. Бараа материалын данстай холбоотой асуудал

*Илрүүлэлт-1:* Шатахууны 2,958.8 мянган төгрөгийн урамшууллыг орлогод авахдаа зардал бууруулж бүртгэсэн байна.

Энэ нь НББОУС-1 "Санхүүгийн тайлангийн толилуулга", MNS-6817-4-2020 стандартын 5.2.1.7.1 "Хамааралтай байх-санхүүгийн тайланд багтсан мэдээлэл шалгагдагч байгууллагын онцлог шинж, санхүүгийн тайлангийн зорилгод хамааралтай байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5.1.4-т "Үнэн зөв байх" гэж заасантай нийцээгүй, санхүүгийн тайлагналын "толилуулга ба тодруулга" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

*Өгсөн зөвлөмж:* Шатахууны урамшууллыг орлогод авахдаа орлого, материалыг нэмэгдүүлэн бүртгэж байх зөвлөмж өгөв.

## Дөрөв. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл:

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шатахууны урамшууллыг орлогод авахдаа зардал бууруулсан бичилт хийж орлого, зардал дутуу бүртгэсэн байна	1	2,958.8			1	2,958.8			1	2,958.8	1	2,958.8
<b>Дүн</b>	<b>1</b>	<b>2,958.8</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>1</b>	<b>2,958.8</b>			<b>1</b>	<b>2,958.8</b>	<b>1</b>	<b>2,958.8</b>

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Шатахууны зардлыг батлагдсан төлөвлөгөөнөөс илүү зарцуулсан, анхан шатын баримтын бүрдэл дутуу гүйлгээ хийсэн байна	1	5,257.6	1	5,257.6								
Бэлтгэн нийлүүлэгтэй худалдан авах гэрээ байгуулахдаа ирүүлсэн үнийн саналаас илүү дүнгээр байгуулж, шилжүүлсэн	1	350.0	1	350.0								
Өмнөх онуудаас шилжин ирсэн авлагын үлдэгдэлтэй, тооцоо нийлж актаар баталгаажуулаагүй байна	1	2,143.9			1	2,143.9						
Урьдчилж орсон орлого дансанд Ковид-19 цар	1	1,816.9					1	1,816.9				

тахлын үед төрөөс хэрэглэгчдэд халаалтын үнийн хөнгөлөлт үзүүлэхэд орж ирсэн санхүүжилтийн болон харилцагч тодорхойгүй үлдэгдэл байна												
<b>Дүн</b>	<b>4</b>	<b>9,568.4</b>	<b>2</b>	<b>5,607.6</b>	<b>1</b>	<b>2,143.9</b>	<b>1</b>	<b>1,816.9</b>				

## Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Тайлант онд эрчим хүчний тарифыг нэмэгдүүлэхээр тооцож төлөвлөгөө баталсан боловч нэмэгдүүлээгүйтэй холбоотойгоор батлагдсан зорилтот түвшний орлогын төлөвлөгөөний биелэлт дутуу байна.	1	163,993.1					1	163,993.1
Тухайн байгууллага нь цахим дэлгүүрт бүртгэлгүй, тайлант оны худалдан авалтын захиалга хүсэлт өгөөгүй, гэрээ байгуулж шууд худалдан авалт хийсэн байна. худалдан авалт хийсэн байна.	1						1	
<b>Дүн</b>	<b>2</b>	<b>255,086.2</b>					<b>2</b>	<b>255,086.2</b>

## Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1			1			
2	Төсөл, хөтөлбөр								
3	ЗГТС								
4	ТТЗ								
5	ТЕЗ								
	<b>НИЙТ</b>	<b>1</b>	<b>1</b>			<b>1</b>			